

**ДАРХАН-УУЛ АЙМГИЙН НУТГИЙН ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГА,
АЛБАН ТУШААЛТАНД ХАНДАЖ ИРҮҮЛСЭН ӨРГӨДӨЛ, ГОМДЛЫН
ШИЙДВЭРЛЭЛТИЙН ТАНИЛЦУУЛГА**

/2019 оны 1 дүгээр улирал/

2019 оны 04 дүгээр сарын 02

Дархан-Уул аймаг

Дархан-Уул аймгийн нутгийн захиргааны байгууллага нь иргэдийн өргөдөл, гомдол, санал, хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэхдээ “Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг хянан шийдвэрлэх тухай” хууль, Засгийн газрын 2005 оны 67 дугаар тогтоол, 2007 оны 8 дугаар албан даалгавар, аймгийн Засаг даргын 2018 оны 01-А/266 дугаар захирамжаар батлагдсан “Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг хүлээн авч шийдвэрлэх журам” болон холбогдох бусад хууль, эрх зүйн актуудыг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн, сум, хэлтэс, агентлагууддаа мэргэжил, арга зүйн удирдлагаар ханган улирал бүр үнэлэлт, дүгнэлт өгч ажиллаж байна.

Аймгийн хэмжээнд нутгийн захиргааны байгууллага, албан тушаалтанд хандаж иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлыг дараах эх үүсвэрээр хүлээн авч байна. Үүнд:

1. Аймгийн нутгийн захиргааны байгууллагуудаар;
2. “Нийтийн үйлчилгээний нэгдсэн төв”-ийн 70371212 дугаарын нээлттэй утсаар;
3. Дархан сумын “Иргэдэд үйлчлэх төв”, төвийн 70371313 дугаарын утсаар;
4. www.darkhan.gov.mn цахим хуудсаар;
5. Аймгийн болон сумдын ЗДТГ-ын “Иргэд хүлээн авах өрөө”-өөр;
6. Засгийн газрын “11-11 төв”-өөр тус тус өргөдөл, гомдлыг хүлээн авч байна.

2019 оны 1 дүгээр улирлын байдлаар Дархан-Уул аймгийн нутгийн захиргааны байгууллага, албан тушаалтанд хандаж 2906 өргөдөл, гомдол ирүүлснээс 2196 өргөдөл, гомдлыг шийдвэрлэж, 238 өргөдөл, гомдлын шийдвэрлэх хугацаа болоогүй байна. Өргөдөл, гомдлын шийдвэрлэлт 92.00 хувьтай байна.

Өргөдөл, гомдлын мэдээг нэгтгэн аймгийн Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж хуралдаанаас өгөгдсөн үүрэг даалгавар, зөвлөмжийг холбогдох газруудад хүргүүлэн үйл ажиллагаанд тусгаж, өргөдөл, гомдлын мэдээг улирал бүр www.darkhan.gov.mn сайтад байршуулан ажиллаж байна.

ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ХЭЛТЭС

**ДАРХАН-УУЛ АЙМГИЙН НУТГИЙН ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГА,
АЛБАН ТУШААЛТАНД ХАНДАЖ ИРҮҮЛСЭН ӨРГӨДӨЛ, ГОМДЛЫН
ШИЙДВЭРЛЭЛТИЙН БАЙДАЛ /2019 оны 1 дүгээр улирал/**

2019 оны 04 дүгээр сарын 02

Дархан-Уул аймаг

Хүснэгт 1

№	Байгууллагын нэр	Нийт ирсэн өргөдөл, гомдлын тоо	Шийдвэрлэж хариу өгсөн	Шийдвэрлэлт		Хугацаа болоогүй	Шийдвэрлэлт /%/
				Бусад байгууллагад шилжүүлсэн	Хугацаа хэтрүүлж шийдвэрлэсэн		
1	АЗДТГ-ын дүн	155	135	4	0	16	90%
2	Сумдын дүн	1378	788	451	0	139	90%
3	Агентлагийн дүн	1373	1273	17	0	83	94%
ДҮН		2906	2196	472	0	238	92%

Өргөдөл, гомдол, санал, хүсэлт /хэлбэрээр нь/

Хүснэгт 2

№	Байгууллагын нэр	Нийт ирсэн өргөдөл, гомдол, санал хүсэлт	Үүнээс					
			Бичгээр	11-11 төвөөр	Цахим хэлбэрээр	Утсаар хандсан	Биечлэн уулзсан	Бусад
1	АЗДТГ-ын дүн	155	72	0	0	35	48	0
2	Сумдын дүн	1378	1217	0	12	57	92	0
3	Агентлагийн дүн	1373	1232	0	0	80	61	0
ДҮН		2906	2521	0	12	172	201	0

Өргөдөл, гомдол, санал, хүсэлтийн агуулга /%-аар/

Хүснэгт 3

№	Байгууллагын нэр	Зонхилж байгаа асуудал /тоо, нийт өргөдөл, гомдолд эзлэх хувь/
1	Дархан-Уул аймаг	<p>Нийт 2906 өргөдлөөс</p> <p>1. Хүсэлт 2803 96.50%</p> <p>2. Санал 11 0.4%</p> <p>3. Гомдол 92 3.2%</p> <ul style="list-style-type: none"> - Тухайн байгууллагаас үзүүлдэг төрөлжсөн үйлчилгээнд хамрагдахыг хүссэн өргөдөл, гомдол 849 /29.7%/ - Нийгмийн халамжийн үйлчилгээнд хамрагдахыг хүссэн 320 /11.21%/ - Газар хүссэн 201 /7.0%/ - Ажилд орох, ажлаас чөлөөлөгдөх, ажил шилжүүлэх хүсэлт 74 /2.6%/ <p>• Дээрх хүсэлтүүдийг шийдвэрлэхийн тулд сумдуудын Засаг даргын Тамгын газар, хэлтэс, агентлагуудад “Угтах үйлчилгээ”-г шинээр ажиллуулж эхэлсэн.</p>

...ooOoo...